



“Тусгай хамгаалалттай газар нутаг, эко аялал жуулчлал” сэдэвт онлайн сургалтын тайлан

2009-01-19

Монгол орны газар нутгийн 14.1 хувийг хамраад байгаа тусгай хамгаалалттай газар нутаг нь ховор ховордсон амьтан, ургамлын тархац, байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалт газрын гол төлөөлөл хамрагдсан байдаг учраас аялал жуулчлалын цөм нутаг болдог. Тусгай хамгаалалттай газар нь эко аялал жуулчлалыг хөгжүүлэх суурь нь юм. Дэлхийд асар хурдтай хөгжиж байгаа аялал жуулчлалын зөв хэлбэрийг буюу тогтвортой, хариуцлагатай аялал жуулчлалыг тусгай хамгаалалттай газарт зөв бодлого, менежменттэйгээр хөгжүүлснээр аялал жуулчлал нь эргээд тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын менежментийг сайжруулах санхүүгийн эх үүсвэр болох бүрэн боломжтой юм.

2008 оны байдлаар нийтдээ 600 орчим аж ахуйн нэгж тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлалын бааз, отог ажилуулж байна. Зарим тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлалын бааз хэт олон болсноор тухайн экосистемд дарамт үзүүлэх болсон. Тиймээс тухайн газар нутгийг тусгай хамгаалалтанд хамруулсан зорилгыг алдагдуулахгүйгээр аялал жуулчлалын зөв хэлбэрийг хөгжүүлэх нь тусгай хамгаалалттай газар нутгийн эрхзүйн бодлого, менежмент мөн мэргэжилтнүүдийн мэдлэг, чадвараас шууд хамаарна. Тусгай хамгаалалттай газар нутагт одоо ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн маш бага хувь нь аялал жуулчлалын дээд боловсрол эзэмшсэн байна. Иймд энэ удаад Алтайн Соёны эко бүс дэх тусгай хамгаалалттай газар нутгийн мэргэжилтнүүдэд зориулж аялал жуулчлалын тухай суурь ойлголтыг өгөх зорилгоор онлайн сургалтыг зохион байгууллаа.

Сургалтыг Байгаль орчин аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай нутгийн Удирдлагын газар, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын захиалгаар ШУТИС-ийн Нийгмийн Технологийн сургуулийн аялал жуулчлал, бүс нутаг судлалын баг иж бүрэн 2 кредитийн онлайн хичээлийг 2008 оны 12 дугаар сард 14 хонгийн хугацаанд зохион байгуулав. Онлайн сургалт нь цаг хугацаа, зардлыг хэмнэх, оролцогчдын тоог хязгаарлахгүйн зэрэгцээ тэдний техник хангамжтай ажиллах чадварыг дээшлүүлэх ач холбогдолтой юм.

Сургалтын зорилго:

1. ТХГ-ын байгаль хамгаалагч, мэргэжилтнүүдийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтын шинэлэг хэлбэрийг турших
2. ТХГ-ын мэргэжилтэнүүдэд аялал жуулчлалын тухай суурь мэдлэгийг олгосноор тухайн тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тэдний хувь нэмрийг дээшлүүлэх

Сургалтын арга зүй, агуулга:

“Тусгай хамгаалалттай газар нутгийн эко аялал жуулчлал” сэдэвт онлайн сургалтаар 32 цагийн лекц, 6 цагийн бие даалт, тестийн хувилбаруудыг бэлдсэн ба энэ ажлын хүрээнд:

1. Модул бэлтгэх
2. Модулын дагуу лекцүүдийг онлайн хэлбэрт оруулах, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын <http://www.econet.mn/> сайтад суурилуулах
3. Оролцогчдод зааварчилгаа өгөх
4. Оролцогчдыг үнэлэх гэсэн ажлууд хийгдсэн болно.

Дээрх сэдвийн хүрээнд хамаарах 32 цагийн лекцийн үндсэн агуулгыг дараах хүснэгтэд харууллаа /хүснэгт 1/. Хичээлийн төлөвлөгөө ёсоор оролцогчид Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын <http://www.econet.mn/> сайт дахь Эко аялал жуулчлалын цуврал хичээл гэсэн хэсгээр нэвтрэн орж лекцийг уншаад лекц тус бүрт харгалзах 20, нийт 100 асуулттай 4 тестийг (15/XII –нд тест 1, 18/XII- тест 2, 22/XII-тест 3, 24/XII-тест 4-ийг хийх) бөглөсөн. Тестийн хариугаа оролцогч өөрөө тэр даруйдаа харж болох ба шаардлагатай мэдээллээ багшаас e-mail-ээр асууж зөвлөгөө авах боломжтой байсан.

Хүснэгт -1

Лекцийн хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө

Модул	Д/д	Сэдэв	Үндсэн агуулга	Цаг
Модул 1 Аялал жуулчлалын тухай ойлголт	1	Аялал жуулчлалын тухай ойлголт	Аялал жуулчлал гэж юу вэ? Олон улсын болон дотоодын аялал жуулчлал, жуулчин, аялагч гэж хэн бэ?	2
	2	Аялал жуулчлалын төрөл хэлбэрүүд	Аялал жуулчлалын төрөл, тэдгээрийн онцлог, төрөл, хамааруулах шалгуурууд	2
	3	Монголын аялал жуулчлалын түүхэн тойм	Монголын аялал жуулчлалын түүхээс, аялал жуулчлалын давуу ба сул тал, төрөөс авч хэрэгжүүлж буй менежментийн чиг үүрэг	2
	4	Аялал жуулчлалын салбарын эрх зүйн тогтолцох	Аялал жуулчлал ба байгаль орчны багц хуулийн хэрэгжилт, тэдгээрийн хоорондын хамаарал	2
Модул 2 Эко аялал жуулчлалын хөгжлийн хандлага	5	Эко аялал жуулчлалын үзэл баримтлал	Эко аялал жуулчлалын зорилго, зорилт, үндсэн элементүүд	2
	6	Аялал жуулчлалаас байгаль экологид үзүүлэх нөлөөлөл	Аялал жуулчлалаас байгаль экологи, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга зам	2
	7	Эко аялал жуулчлалаас нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллүүд	Нийгэм эдийн засагт аялал жуулчлалаас үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөллүүд, тэдгээрийн онцлог	2
	8	Эко аялал жуулчлалын байгаль орчны менежмент	Эко аялал жуулчлалыг хөгжүүлэх үндсэн үүрэг, хөгжлийн үндсэн төрөл, хөгжүүлэх арга замууд	2
Модул 3 Тусгай хамгаалалттай газар	9	Тусгай хамгаалалттай газар нутаг ба аялал жуулчлалын хамаарлын асуудлууд	Тусгай хамгаалалттай газар нутагт хийж буй аялал жуулчлалын онцлог,	2
	10	Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн хөгжил ба нутгийн иргэдийг эко аялал жуулчлалд татан оролцуулах	Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсэд амьдарч буй иргэдийг аялал жуулчлалд татан оролцуулж, тэдний эдийн засгийн чадавхийг сайжруулах	2

	11	Тусгай хамгаалалттай газар нутагт ирж буй гийчдийг чиглүүлэн зохицуулах	Тусгай хамгаалалттай газар нутагт ирж буй жуулчдын ачааллыг хуваарилах, байгаль орчин зүй зохистой харьцах хандлагыг төрүүлэх	2
	12	Тусгай хамгаалалттай газруудын удирдлагын шийдвэл зохих стратеги	Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын зүгээс байгаль орчин, аялал жуулчлалын менежментийн үүрэг	2
Модул 4. Эко аялал жуулчлалын хөгжлийн хандлага	13	Дэлхийн өв ба аялал жуулчлал	ЮНЕСКО-д бүртгэгдсэн дэлхийн өв ба тэдгээрийн төрөл ангилал, шалгуур, тэдгээрийг аялал жуулчлалын үзмэр болгох нь	2
	14	Хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутгийн эко аялал жуулчлал	Хил дамнасан тусгай хамгаалалттай газар нутгийн түүх, тухайн газрыг байгуулах шалгуур, хамтын ажиллагааны түвшин тогтоох асуултууд	2
	15	Биологийн төрөл зүйлийн тухай конвенцийн тусгай хамгаалалттай газар нутгийн үйл ажиллагааны хөтөлбөр	Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөний бүтцэд биологийн төрөл зүйлийг хамгаалах арга технологийг нэвтрүүлэх арга замууд, тэдгээрийн онцлог	2

Оролцогчид төлөвлөгөөний дагуу лекцээ судлаад тест бөглөсний дараа олсон авсан мэдлэгээ чадвар болгох, цаашид хөгжүүлэх, бүтээлчээр хэрэгжүүлэхэд дөхөм болгох зорилгоор дараах бие даалтын сэдвүүдийг сонгож тавьсан/хүснэгт -2/.

Хүснэгт - 2

Бие даалтын хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө

Модул	Д/д	Сэдэв	Хийх ажлын үндсэн агуулга
Модул 1-ийн бие даалтын ажил	1	Орон нутаг дахь аялал жуулчлалын нөөцүүд	<ul style="list-style-type: none"> Алтай Соёны бүс дэх аялал жуулчлалын нөөцүүдийг орон нутгийн газрын зурагт тэмдэглэх, түүнд түшиглэсэн эко аялал жуулчлалын төрлүүдийг гаргах, зураг мэдээ материал цуглуулах Улирлын хуанли хөтлөх
Модул 2-ын бие даалтын ажил	2	Аялал жуулчлалаас байгаль, хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг буруулах арга зам ба олон улсын туршлагауд	<ul style="list-style-type: none"> Аялал жуулчлалаас байгаль экологид нөлөөлж буй сөрөг нөлөөллүүдийг тодорхойлох Байгаль орчинд үзүүлж буй хэмжээ сөрөг нөлөөллийн хэмжээ, түүнийг бууруулах арга замууд Аялал жуулчлалаас байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгаж буй дэлхийн улс орнуудын туршлагаудыг судлан мэдэх
Модул-3-ын бие даалтын ажил	3	Тусгай хамгаалалттай газар нутагт тулгарч буй бэрхшээлүүд, түүнийг шийдвэрлэхэд иргэдийн оролцоо	<ul style="list-style-type: none"> Аялал жуулчлалын байгууллагатай хамтран ажиллах нөхцлүүд Нутгийн иргэдийг аялал жуулчлалд татан оролцуулах Тусгай хамгаалалттай газар нутагт тулгарч буй бэрхшээлүүдийг гаргаж ирэх

Үнэлгээ

Дээрх сэдвүүдийн дагуу оролцогчид бие даалтаа хийгээд багшийн e-mail хаягруу илгээсэн ба тестийн үнэлгээ болон бие даалтын ажлын үнэлгээг өгч 2 кредит бүхий сертификат олгосон. Нэг кредитэд ногдох цагийг ШУТИС-ийн үнэлгээгээр авч үзлээ.

Үр дүн

Багийн ахлагч проф Н.Галиймаа Ховд аймагт 2008-12-р сард Алтай-Соёны эко бүс нутагт орших ТХГ-ын хамгаалалтын захиргааны дарга мэргэжилтэнүүдийн оролцсон “Тусгай хамгаалалтын газар нутгийн менежментийн төлөвлөгөө” сэдэвт семинарт оролцож, онлайн хичээлийг хэрхэн ашиглах тухай зааварчилгаа өгсөн ба Тусгай хамгаалалтын газар нутгийн ажилтнуудаас доор нэр дурдсан хүмүүс <http://www.econet.mn/>сайт руу орж бүртгүүлсэн. Давхардсан тоогоор нийт 63 хүн тус сайт руу орсноос сургалтанд хамрагдах ёстой 18 хүний нэрийг доор дурдлаа.

Сургалтанд хамрагдсан хүмүүсийн нэрс	Байгууллага	Бүртгэл	И-мейл хаяг	Бүртгүүлсэн он сар өдөр	
1. Ганзориг	ХУНУТХГ	Registered	ganzaa2580@yahoo.com	2008-12-22 12:49:27	68
2. Х.Назгуль	МАНУТХГ	Registered	nazkana@fastmail.fm	2009-01-12 10:18:30	69
3. Наранцэцэг	ХНУТХГ	Registered	naraa_hatgal@yahoo.com	2008-12-08 19:50:53	70
4. Баянмөнх		Registered	Baynaa_gan@yahoo.com	2008-12-08 19:38:11	71
5. Цэвээнравдан	ДБХС	Registered	tseveenravdan@wwf.mn	2008-12-14 12:11:36	72
6. Аманбек	МАНУТХГН	Registered	amanbekg@yahoo.com	2008-12-19 17:14:07	73
7. Байгальмаа	ДБХС	Registered	baigal_hovd@yahoo.com	2008-12-08 19:34:47	74
8. Г.Олонбаатар	Говь-Алтайн аймгийн БОА	Registered	olnoo_gz@yahoo.com	2008-12-26 16:46:33	75
9. Жаргалцэцэг	Говь-Алтайн аймгийн БОА	Registered	jagaa303@yahoo.com	2008-12-26 15:19:39	76
10. Жавзансүрэн	УНАСУТХГ	Registered	e_javzan@yahoo.com	2008-12-11 11:27:48	78
11. Enebish		Registered	enebish_d@yahoo.com	2008-12-14 12:05:47	79
12. jamiyanjav	Хөвсгөл УТХГН	Registered	jamiyanjav@yahoo.com	2008-12-17 19:34:46	81
13. э		Registered	uyanga2560@yahoo.com	2009-01-04 19:52:58	84
14. Monkhjargal		Registered	siskim_2006@yahoo.com	2009-01-05 15:08:00	85
15. nasaа		Registered	g_ganaa7818@yahoo.com	2009-01-06 17:41:04	86
16. boloroo		Registered	ochir_maral@yahoo.com	2009-01-06 23:12:15	87
17. оюунтунгалаг		Registered	oyukuna@yahoo.com	2009-01-12 20:05:55	88
18. Monkhtuya		Registered	monkh_kh@yahoo.com	2009-01-15 12:06:27	89

Онлайн сургалтанд бүртгүүлсэн 18 хүнээс 4-р тестийг 2 хүн, 2-р тестийг 5, 1-р тестийг давхардсан тоогоор 63 сонсогч бөглөснөөс сургалтанд оролцогч Монгол Алтайн нурууны Улсын ТХГН-ын Хамгаалалтай захиргааны мэдээлэл, сурталчилгааны мэргэжилтэн Х.Назгул сургалтын агуулгыг хугацаанд нь 25/XII-нд бүрэн дуусгаж сертификатын болзол хангасан болно.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын дэмжлэгтэйгээр ТХГ-ын мэргэжилтэнүүдэд зориулан явуулсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн эко аялал жуулчлал” сэдэвт энэхүү сургалтын үр дүнд:

- Тусгай хамгаалалтын газар нутгийн мэргэжилтэнүүд онлайн сургалтанд хамрагдах анхны мэдлэг, дадлыг эзэмшсэн
- Тусгай хамгаалалтын газар нутгийн хамгаалалтын захиргааны мэргэжилтэнүүд эко аялал жуулчлалыг хэрхэн яаж хөгжүүлэх менежментийн анхны мэдэгдэхүүнтэй болсон

Дүгнэлт

- Тусгай хамгаалалтын газар нутгийн мэргэжилтэнгүүдийн зайлшгүй эзэмшсэн байх шаардлагатай мэдлэг, чадварыг онлайн хэлбэрээр эзэмшүүлэх хүний нөөц, техникийн боломж байгаа нь энэхүү төслийн үр дүнгээс харагдлаа.
- Сургалтын чанарыг сайжруулахын тулд оролцогчдын техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- Сургалтанд оролцогчдыг бүрэн дүүрэн хамруулах, үр дүнг тооцох механизм боловсруулах шаардлагатай байна.
- Ажлын ачаалал ихтэй үед сургалтын төлөвлөгөөг уян хатан болгох, цаг хугацааны хувьд урт байх нь оновчтой байна.

Онлайн сургалтыг зохион байгуулсан багийн гишүүд:

1. Проф. Н.Галиймаа
2. Багш Г.Тунгалагтуяа
3. Багш Б.Алтанхуяг
4. Ахлах багш Г.Солонго
5. Компьютерийн багш А. Бадралтөр
6. Веб дизайнер Дөлгөөн